



**“ДОРНОД ХУДАЛДАА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 03 дугаар сарын 13

№/2024/01

Хэрлэн сум

**Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59, 60, 61, 65, 67 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай” журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. “Дорнод худалдаа”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн Мягмар гарагийн 14:00 цагт Дорнод аймгийн Хэрлэн сумын 6 дугаар багт байрлах “Дорнод худалдаа” ХК-ийн байранд зарлан хуралдуулсугай.

Хоёр. Ээлжит хурлын дэгийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Гурав. Хурлыг нийтэд хүргэх зарын загварыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

Дөрөв. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлыг “Санал авах хуудас”-ыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг дөрөвдүгээр асуудлаар баталсугай.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдрийг 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөр тогтоосугай.

Долоо. Хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2024 оны 03 дугаар сарын 31-ны 17:00 цагаар тогтоосугай.

Найм. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын дарга Д.Шинэбаяр, тооллогын комиссын дарга Д.Тунгалагтуул, гишүүд Л.Цэдэн, Ц.Содбаяр, хурал зохион байгуулах комиссын дарга Д.Шинэбаяр, гишүүд Л.Цэдэн, Б.Батцэцэг нарыг тус тус томилсугай.

ЕС. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид энэхүү шийдвэрийн дөрөвдүгээр хавсралтад заасан бичиг баримтыг 2024 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс 31-ний өдөр хүртэл Даваа-Баасан гарагийн 09:00-17:00цагийн хооронд компанийн байранд нарийн бичгийн даргаас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

Арав. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцуулах эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллэх, энэ мэдээллийг дээрх хэлбэр шаардлагын дагуу анх мэдээллэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 03 дугаар сарын 29-ний өдөр дахин мэдээллэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

Арван нэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх, хурлын зар мэдээг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоол "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам"-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэж ажиллахыг гүйцэтгэх захиралд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭБАДАМ